



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/338

Чингис хот

Хот хоорондын зорчигч тээврийн  
хөдөлгөөний талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Улсын онцгой комиссын 2021 оны 7 сарын 06-ны өдрийн 23 хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт зорчих иргэд (PCR-ын шинжилгээ 48 цаг, түргэвчилсэн шинжилгээ 24 цагийн хугацаанд хүчинтэй)-ийн шинжилгээний хариуг, сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн бол энэ талаарх Эрүүл мэндийн байгууллагын магадалгааг үндэслэн нэвтрүүлсүгэй.

2. Шалган нэвтрүүлэх цэгээр зорчигчдын шинжилгээний хугацаа дууссан, дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдаад 14 хоносон бүх иргэдээс Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/12 дугаар тушаалаар баталсан журмын дагуу төлбөртэйгээр түргэвчилсэн шинжилгээ авах, вакцины бүрэн тунд хамрагдаагүй 5-аас дээш насны хүүхдээс түргэвчилсэн шинжилгээг түүвэрлэн үнэ төлбөргүй авч нэвтрүүлэх (нэг өрхөөс нэг хүүхэд гэсэн зохицуулалтаар түүвэрлэн авах) ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д даалгасугай.

3. Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлтгэл бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр), сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг түргэвчилсэн болон PCR-ын шинжилгээг үндэслэн 2021 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэх саналыг Авто тээврийн үндэсний төвд уламжлан шийдвэрлүүлж, холбогдох бэлтгэлийг хангаж ажиллахыг Авто тээврийн төвийн дарга (Б.Ганбат)-д үүрэг болгосугай.

2.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/332 дугаар захирамжийн 2 дугаар заалтыг хүчингүй болгосугай

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ